



БОГД БАНК
ИГЭЛ ТҮГЭЭНЭ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Огноо: 2024.03.15

№ 24/41

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйл, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.7, 62.1.9, 62.1.13, 62.1.15, 62.1.16, 65 дугаар зүйл, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12-р сарын 14-ний өдрийн №377 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 03-р сарын 15-ны өдрийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. “Богд банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал /цаашид “Хурал” гэх/-ыг 2024 оны 04-р сарын 26-ны өдөр 11:00 цагт Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайвны өргөн чөлөө 17, Блю Скай цамхаг, 2-р давхар, Эмиралд танхимд зохион байгуулж хуралдуулсугай.
2. Ээлжит хурал зарлах тухай мэдэгдлийг 2024 оны 03-р сарын 18-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал /Г.Саруул/-д даалгасугай.
3. Ээлжит хурал хуралдуулах тухай зар мэдээг компанийн болон Хөрөнгийн биржийн цахим хуудас, өдөр тутмын хоёр сонингоор дамжуулан 2024 оны 03-р сарын 20-ны өдөр, 2024 оны 04-р сарын 04-ний өдөр тус тус мэдээлэх ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
4. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 04-р сарын 08-ны өдрөөр тогтоосугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:
 - 5.1. “Богд банк” ХК-ийн 2023 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
 - 5.2. Ногдол ашиг хэрхэн хуваарилах талаарх товч танилцуулга;
 - 5.3. ТУЗ-ийн 2023 оны үйл ажиллагааны тайлантай танилцаж баталгаажуулах;
 - 5.4. ТУЗ-ийн 2024 оны зардлын төсвийг батлах;
 - 5.5. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж, дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;
6. Ээлжит хурлын хэлэлцэх асуудлаар гаргах хурлын шийдвэрийн төсөл, тэдгээрийн танилцуулга, саналын хуудас зэрэг хувьцаа эзэмшигч нарт хүргэх хурлын материалыг 2024 оны 03-р сарын 25-ны өдөрт багтаан бэтлгэж үнэт цаасны брокер дилерийн компанид хүргүүлж хувьцаа эзэмшигчдээс хурлын материалтай

ажлын өдрийн 10:00-17:00 цагийн хооронд ирж танилцах боломж бүрдүүлж ажиллахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

7. Ээлжит хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Комиссын дарга: Б.Онон
Комиссын гишүүн: Ж.Ууганчулуун
Комиссын гишүүн: Э.Сэргэлэн

8. Хурал зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.
Үүнд:

Хурал зохион байгуулах комиссын дарга: Б.Уламбаяр /Богд банк ХК-ийн Үйл ажиллагаа, хүний нөөцийн газрын захирал/

Гишүүд: Д.Төрмандах /Ерөнхий аудитор/

Гишүүд: Б.Нармандах /Хуульч/

Гишүүд: Ө.Өнөржаргал /Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн ахлах мэргэжилтэн/

Гишүүд: Г.Цэрмаа /Хүний нөөцийн мэргэжилтэн/

Гишүүд: М.Хүдэрчулуун /Маркетингийн газрын ахлах мэргэжилтэн/

9. “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар”-ыг нэгдүгээр, “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг”-ийг хоёрдугаар, хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотойгоор “Хувьцаа эзэмшигчид танилцуулах баримт бичгийн жагсаалт”-ыг гуравдугаар, хувьцаа эзэмшигчдээс санал авах “Саналын хуудас”-ыг дөрөвдүгээр, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах шийдвэрийн төслүүдийг саналын хуудасны хавсралтаар тус тус баталсугай.

10. Хуралд биечлэн оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчийг саналаа урьдчилан өгөх боломжоор хангаж “БиДиСек ҮЦК” ХК-ийн Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө 27/1, Төв байр хаягаар, Богд банк ХК-ийн Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж 3, Бодь цамхаг, 4 дүгээр давхар хаягаар тус тус дамжуулан авах ба саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацааг 2024 оны 04-р сарын 23-ны өдрийн 15:00 цаг байхаар тогтоосугай.

11. Хурлын даргаар “Богд банк” ХК-ийн ТУЗ-ийн дарга /Л.Болдхуяг/-ыг томилсугай.

12. Хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу 2024 оны 04-р сарын 29-ний өдөр Монголын Хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд тус тус хүргүүлэхийг хурал зохион байгуулах комиссын дарга /Б.Уламбаяр/-т үүрэг болгосугай.

13. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих, холбогдох мэдээлэл, баримт бичгийг эрх бүхий байгууллагад хүргүүлэх, бүртгүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг Дотоод аудитын газар /Д.Төрмандах/-т даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.БОЛДХУЯГ